



ХЭНТИЙ АЙМАГ
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 09 өдөр

Дугаар А103

Бор-Өндөр

Өмч хамгаалах байнгын зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4 дэх заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 65 дугаар тогтоолын хавсралт, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны арван нэгдүгээр хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Бор-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын эд хөрөнгө хадгалалт, хамгаалалт, ашиглалтад байнгын хяналт тавих үүрэг бүхий өмч хамгаалах байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:

Б.Мөнх-Оргил

Хүйх 5 дугаар багийн Засаг дарга

Зөвлөлийн бичгийн дарга:

Г.Болортуяа

Нягтлан бодогч

Зөвлөлийн гишүүд:

Б.Оюунтуяа

Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн

Г.Мягмарсайхан


Бумбат 3 дугаар багийн Зохион байгуулагч

Э.Гуамарал

Хүйх 5 дугаар багийн Зохион байгуулагч

2. Засаг даргын Тамгын газрын хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшил, ашиглалтад байнгын хяналт тавьж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллахыг өмч хамгаалах байнгын зөвлөлд үүрэг болгосугай.

ДАРГА



З.УУГАНЖАРГАЛ